



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ШИНЭЖИНСТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

Захиргааны хэм хэмийн г
актын улсын нэгдсэн г
2024 оны 02 сарын 26-ны
одриин 6657 дугаарт бүртгэл

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар 111

Залаа

“ Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг ”
шинэчлэн тогтоох тухай

Монгол улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль”-ийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, 35 дугаар зүйлийн 1.10 дахь заалт, 35 дугаар зүйлийн 1.14 дахь заалт, Татварын ерөнхий хуулийн 2 дугаар бүлгийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.2 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.7 дахь заалт, Сангийн сайд, Байгаль орчны сайдын хамтарсан 2018 оны 192,А/243 тушаалыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, хоолны газар, үсчин гоо сайхан, дугуй засвар, цех, дэлгүүрүүд, албан байгууллагууд, айл өрхүүдийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2.Төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, үйлчилгээний газрууд, ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагуудын хог хаягдлын хураамжийг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлсүгэй.

3.Өрхийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хэмжээгээр сар бүр Орчим хүчний үйлчилгээний төлбөргэй хамтатган төвлөрүүлж, хог хаягдлын хураамжийн орлогоос 80 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж ажилласугай.


4.Орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлогыг хог хаягдал цуглуулах, ачиж тээвэрлэх, булшлах зардалд зарцуулан ажлын үр дүн, гүйцэтгэлийг хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (Д.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

5.Монгол улсын захиргааны ерөнхий хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлд бүртгүүлж тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын

642301036

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Т.Цэнгэлмаа)-д даалгасугай.

6.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг шинэчлэн тогтоох тухай” Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 11 дүгээр сарын 28-ний өдрийн 70 тоот тогтоолыг хүчингүй болгосонд тооцсугай.

ДАРГА  Н.ЖАРГАЛСАЙХАН

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны
 2014 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн
 10 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралт

Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага, албан байгууллага, айл өрхүүдийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ

№	Хог хаягдлын хураамж төлөх аж ахуйн нэгж, албан байгууллага, айл өрхүүд	Сар бүр төлөх хураамжийн хэмжээ, төгрөг	Жилд төлөх хураамжийн хэмжээ, төгрөг	Тайлбар
1	Засаг даргын Тамгын газар	15000	180000	
2	Ерөнхий боловсролын сургууль	15000	180000	
3	Цэцэрлэг	15000	180000	
4	Соёлын төв	15000	180000	
5	Эрүүл мэндийн төв	15000	180000	
6	Цаг уур	15000	180000	
7	Хаан банк, Төрийн банк	15000	180000	
8	Холбоо	15000	180000	
9	ШТСтанцууд	15000	180000	
10	Уурын зуух	85000	680000	
11	Сумын төвийн өрхүүд	Иргэнээр 1000, Өрхөөр 5000		1-3 ам бүлтэй бол өрхөөр, 4-өөс дээш ам бүлтэй бол иргэнээр тооцох
12	Дэлгүүр	10000	120000	
13	Дугуй засвар, үсчин, цех	10000	120000	
14	Үйл ажиллагаа байгаа аж ахуйн нэгж	15000	180000	
15	Гаднаас ирж түр хугацаагаар л задгай наймаа эрхлэгчид	15000		Хоног тутам
16	Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллага	2000000	24000000	
17	Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллагууд	500000		Ажиллах хугацаагаар
18	Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж байгууллагын (кемпийн, замын, өрөмдлөгийн барилгын болон бусад үйл ажиллагаа эрхлэгч) туслан гүйцэтгэгчид	1000000	12000000	

.....оОо.....